



ОРХОН АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН  
АЛБАН ХААГЧДЫГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР /2021-2024 ОН/

### НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ

Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8 дэх, 55 дугаар зүйлийн 55.3 дэх заалтанд төрийн албан хаагчид “Өөрийн мэдлэг, чадвараа байнга хөгжүүлж, хийсэн ажлынхаа гүйцэтгэл үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх, Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ” гэж тус тус заасан нь хөтөлбөр боловсруулах үндэслэл болж байна.

Аймгийн хүн амын тоо нэмэгдэж байгаатай холбогдуулан түүнийг дагаад төрийн үйлчилгээг авах иргэдийн тоо өсөж байна. Иймд төрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах, хурдан шуурхай, чирэгдэл, доголдолгүй үйлчлэхэд төрийн албан хаагчдын сургалтын хэрэгцээг тодорхойлж, удирдлагын чадавхийг хөгжүүлэх, байгууллагын хөгжлийн хандлагыг хүний нөөцийн хөгжлийн хандлага, гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулан хэрэгжүүлж, албан хаагчдыг хөрвөх чадвартай болгон хөгжүүлэх шаардлагатай байна.

### ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Төрийн албан хаагч болон салбарын ажилтнуудын ажиллах урам зориг, хүсэл эрмэлзлийг бий болгоход чиглэгдсэн сургалтуудад тогтмол хамруулах, суралцах таатай нөхцөл бололцоогоор хангах, ур чадвараа хөгжүүлэх, мэдлэг чадварыг нэмэгдүүлж чадваржуулахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

#### Хөтөлбөрийн зорилт:

Зорилт-1: Төрийн албаны хуулийн хэрэгжилтийг хангах мэргэшүүлэх багц сургалтад албан хаагчдыг тасралтгүй хамруулна.

**Зорилт-2:** Мэдлэг чадварыг дээшлүүлэх цаг үеийн зорилтот сургалтад нийт албан хаагчдын 50-аас доошгүй хувийг хамруулна.

**Зорилт-3:** суралцагч байгууллагын соёлыг төлөвшүүлнэ

**Зорилт-4:** Сургалтын орчин, нөхцөл, хэрэглэгдэхүүн, техник хэрэгсэлийг сайжруулна.

**Зорилт-5:** Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тогтолцоог боловсронгуй болгоно.

## **ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

3.1. 2024 он гэхэд төрийн албан хаагчид мэргэшүүлэх багц сургалтад 100 хувь хамрагдсан байна.

Шалгуур үзүүлэлт нь:

3.1.1. Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтад албан хаагчдаа бүрэн хамруулсан байна.

3.1.2. Мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо нэмэгдсэн байна.

3.2. Мэдлэг чадварыг дээшлүүлэх цаг үеийн зорилтод сургалтад нийт албан хаагчдын 80 хувийг хамруулна.

Шалгуур үзүүлэлт нь:

3.2.1. Сургалтад хамрагдсан албан хаагчдын хувь 100

3.2.2. Мэдлэг чадвар нэмэгдсэн байдал 80 хувь

3.3. Суралцагч байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.

Шалгуур үзүүлэлт нь:

3.3.1 Байгууллагын дотоодод зохион байгуулагдах сургалт, семинар улиралд 3 доошгүй удаа зохион байгуулсан байна.

3.3.2. Дагалдан суралцсан ажилтны тоо 15

3.3.3. Бие даан суралцаж хавсарсан мэргэжил, боловсролын зэрэг авсан ажилтны тоо 50 хувь

3.4. Сургалтын орчин нөхцөл, техник хэрэгсэлийг сайжруулна.

Шалгуур үзүүлэлт нь:

3.4.1. Интернетийн хурд 20 хувиар нэмэгдсэн байх

3.4.2 Боловсруулагдсан сургалтын гарын авлага, хэрэглэгдэхүүний тоо 10

3.4.3. Зайн сургалтад хамрагдсан адбан хаагчдын 5 буюу 25 хувь

3.4.4 Ажлын байран дээрх сургалтад хамрагдсан адбан хаагчдын 17 буюу 80 хувь

3.4.5. Цахим мэдээллийн санг бурдүүлсэн байна.

3.5. Сургалтын хөтөлбөрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт боловсруулсан байна.

Шалгуур үзүүлэлт нь:

3.5.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн үр дүн

3.5.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн үр дүнг сургалтын хөтөлбөрт тусгаж сайхруулсан байдал

## **ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТУУДЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

4.1. Төрийн албаны хуулийн хэрэгжилтийг хангах мэргэшүүлэх багц сургалтад албан хаагчдыг тасралтгүй хамруулах зорилтын хүрээнд:

4.1.1. Албан хаагчдын томилолтыг сургалтын удирдамж, төлөвлөгөөг үндэслэн албан томилолт тухай бүрт олгоно.

4.1.2. Төрийн албан хаагчийг 60 хүртэлх хоногийн хугацаагаар эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу “Төрийн хөрөнгө”-өөр гадаад, дотооддоо давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэхэд түүний эрхэлж байгаа албан тушаалын цалинг нь олгоно.

4.1.3. Гадаадад 10-аас дээш хоногийн мэргэжил дээшлүүлэх давтан сургалтад хамрагдах албан хаагчдад жилд 1 удаа хуримтлалын сангаас хуримтлалын журмын дагуу буцалтгүй тусламж олгоно.

4.2. Мэдлэг чадварыг дээшлүүлэх цаг үеийн зорилтод сургалтад нийт албан хаагчдын 100 хувийг хамруулах зорилтын хүрээнд:

4.2.1. Төрийн албан хаагчийн ажил мэргэжлийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх

4.2.2. Төрийн захиргааны албан хаагчийн төрийн алба хаасан хугацааг тодорхойлж, нэмэгдэл олгох хувийг Засгийн газраас /2018 оны 382 дугаар тогтоол, 2020 оны 151 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон/ баталсан журмын дагуу байгууллагын эрх баригчийн тушаалаар тогтоох

4.2.3. Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв шинээр олгох, ахиулах асуудлыг жил бүрийн 2 дугаар сард ТАЗСЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, аймгийн Засаг даргын захирамжийн дагуу олгоно.

4.2.4. Аймгийн Засаг даргын “Зэрэг, дэв олгох тухай” захирамжийг үндэслэн тухайн байгууллагын даргын тушаалаар уг албан тушаалтанд олгох зэрэг дэвийн нэмэгдлийг зохих журмын дагуу тогтоож баталгаажуулна.

4.2.5. Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр төвшинд гүйцэтгэдэг буюу бусдаас илүү дэвшилтэд арга барилаар ажиллаж өндөр амжилт гаргасан ажилтанд ур чадварын нэмэгдлийг Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан нийтлэг журмыг үндэслэн байгууллагын эрх баригчийн тушаалаар олгоно.

4.2.6. Төрийн үйлчилгээний албаны тухайн салбарын ажлын онцлогийг харгалзан мэргэшлийн зэрэг, зэргийн нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу тухайн байгууллагын эрх баригчийн тушаалаар шийдвэрлэнэ.

4.2.7. Албан тушаалтны цалингийн сүлжээний шатлал ахиулах буюу бууруулах шалгуур үзүүлэлтийг тухайн албан тушаалтны үр дүнгийн гэрээний биелэлтийг үндэслэн хамт олны буюу даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, байгууллагын эрх баригчийн тушаалаар шийдвэрлэнэ.

4.3. Суралцагч байгууллагын соёлыг төлөвшүүлэх зорилтын хүрээнд:

4.3.1. Дотроо суралцах нөөц боломжийг судалж дагалдан суралцах сургалтын арга хэлбэрийг хэрэгжүүлэх

4.3.2. Төрийн албан хаагч бие дааж хөгжих орчин, нөхцөлийг бүрдүүлэх

4.3.3. Байгууллага хооронд хамтын ажиллагааны хүрээнд мэргэжилтэн солилцож ажиллуулах, туршлага судлах

4.3.4. Бүх шатны удирдлагууд болон бусад албан тушаалтнуудад “Суралцагч байгууллага” болон “Өөрчлөлтийн удирдлага”-ийн асуудлаар ойлголт, мэдлэг бий болгох

4.3.5. Суралцагч байгууллагад шаардагддаг удирдагч, баг, бүлэг болон хувь хүний мэдлэг чадварыг хөгжүүлэх цогц механизм бүрдүүлэх

4.4. Сургалтын орчин нөхцөл, техник хэрэгсэлийг сайжруулах зорилтын хүрээнд:

4.4.1. Зайн сургалтын техник, тоног төхөөрөмж, программ хангамж бүхий танхим тохижуулах

4.4.2 Төрийн албан хаагчдад зайн сургалтад мэплэг, ур чадвар эзэмшиүүлнэ.

4.5. Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх тогтолцоог боловсронгуй болгох зорилтын хүрээнд:

4.5.1 Төрийн албан хаагчдыг шилж сонгох механизмыг боловсронгуй болгох

4.5.2. Ажилтнуудад байгаа нуугдмал нөөцийг илрүүлэх механизм бий болгох

4.5.3. Албан хаагчдыг өөрчлөн байршуулах, карьер өсгөх тогтолцоог бүрдүүлэх

4.5.4. Тухайн ажилтныг хөгжүүлэх хэрэгцээг байгууллагын тэргүүлэх чиглэл, өөрчлөлтөд уялдуулан тодорхойлох

4.5.5. Тухайн ажилтны хөгжлийн хэрэгцээний хангалтыг зохион байгуулах арга хэмжээ авах

## **ТАВ. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА**

5.1. Хөтөлбөрийг 2021-2024 онд хэрэгжүүлнэ.

- Нэг дэх үе шат (2021-2022): хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх
- Хоёр дахь үе шат (2023-2024): хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үр дүнг үнэлэх

## **ЗУРГАА. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ НӨӨЦ**

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

6.1.1. Улсын төсөв

6.1.2. Орон нутгийн төсөв

6.1.3. Олон улсын байгууллага, хандивлагч орнуудын буцалтгүй тусламж, төслийн санхүүжилт

6.1.4. Бизнесийн байгууллага иргэдийн хандив

6.2. Хөтөлбөрийн хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсвийн төсөлд тусган батлуулж, санхүүжүүлнэ.

## **ДОЛОО. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ**

7.1. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудит хариуцсан мэргэжилтэн гүйцэтгэнэ.

7.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, түүний үр дүнгийн талаарх мэдээ, тайланг ил тод, нээлттэй мэдээлнэ.

7.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн 1-р үе шатны үнэлгээг 2022 онд, 2-р шатны үнэлгээг 2024 онд хийнэ.

7.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үйл ажиллагааны төлөвлөгөөг жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор дүгнэж, тайлагнана.

## **НАЙМ. ХӨТӨЛБӨРИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

8.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага арга зүй, зохицуулалтаар хангах, хяналт тавих үүргийг газрын дарга, хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн нар хэрэгжүүлнэ.

- 8.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг Захиргаа аж ахуйн албаны дарга зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллах бөгөөд сургалт сурталчилгаа хариуцсан ажилтан хариуцаж ажлыг зохион байгуулна.
- 8.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллага нь албан хаагч нэг бурийг ажлын байранд сургах талаар байгууллагын дотоод журмын тусган хэрэгжүүлнэ
- 8.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг жилээр төлөвлөнө. Төлөвлөгөө жил бүр албан хаагчдын саналыг үндэслэн боловсруулж батлуулна.
- 8.5. Хөтөлбөрийн санхүүжилтийг хөтөлбөрт заасан арга хэмжээний хүрээнд тухайн жилийн төсөвт тусгагдсан хөрөнгийн дүнд багтаан батлагдсан хуваарийн дагуу зарцуулж тайлагнана.

#### **ЕС. ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ, ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА**

- 9.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчим баримтална.
  - 9.1.1. Ил тод, нээлттэй байх
  - 9.1.2. Тэгш, хүртээмжтэй байх
  - 9.1.3. Үр дүнд чиглэсэн байх
  - 9.1.4. Бүтээлч, эрэлхийлэгч байх
  - 9.1.5. Түншлэл, хамтын ажиллагаанд тулгуурлах
- 9.2. Хөтөлбөр нь дараах байгууллагуудтай идэвхитэй хамтын ажиллагааны үр дүнд хэрэгжинэ.
  - 9.2.1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
  - 9.2.2. Аймгийн Засаг даргын тамгын газар
  - 9.2.3. Бусал холбогдох газраас зохион байгуулах сургалт семинар
  - 9.2.4. Дотоодын сургалт
- 9.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын үүрэг:
  - 9.3.1. Удирдан чиглүүлэх чиг үүргийг 100 хувь хангаж ажиллана.
  - 9.3.2. Сургалтын танхим, тоног төхөөрөмжөөр 100 хувь ханган ажиллана.
  - 9.3.3. Гарын авлага тараах материалыар 100 хувь хангаж ажиллана.
- 9.4. Хөтөлбөрийг оролцогч талууд нь хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж, уг санамж бичгээр хүлээсэн тус тусын үүргээ бүрэн биелүүлж ажиллана.